



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

ДЭЭД БОЛОВСРОЛЫН
БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

ЦУВРАЛ
№12

2018 ОНЫ 8 САР



*"Тогтвортой хөгжлийн бүх зорилго нь
эцсийн эцэст боловсролтой холбоотой."
Малала Юсафзай*



ОРШИЛ

Одоогоос 3 жилийн тэртээ дэлхий дахины удирдагчид Нью Йорк хотноо болсон НҮБ-ын Дээд хэмжээний уулзалтын үеэр Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг тодорхойлсон билээ. 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгууд бол дэлхийн нийт улс орнуудын хүсэн мөрөөдөж байгаа ихээхэн том хүсэл эрмэлзэл

бөгөөд өндөр хөгжилтэй, хөгжиж байгаа болон ядуу буурай улс орон гэж ялгахгүйгээр дэлхий нийтээрээ эдгээр зорилгуудыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхээр амлалт авснаараа урд өмнө байгаагүй чухал ач холбогдолтой юм.



2016 онд Монгол Улсын Их Хурлаас “МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”-ыг баталсан байна. Манай улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэлхий дахины тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй харьцуулан үзэхэд “Далай тэнгисийн нөөцийг хамгаалах” гэсэн 14-р зорилгоос бусад 16 зорилго шууд хамааралтай байна. Үндэсний статистикийн хорооноос жил бүр тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг 233 үзүүлэлтээр гаргадаг бөгөөд 113 үзүүлэлт нь статистикийн өнөөгийн мэдээ баримт дээр тулгуурлан шууд

гардаг ажээ. Харин 120 үзүүлэлтийг тооцож гаргахад хүндрэлтэй байгааг тэмдэглэсэн байна.

Их, дээд сургууль бол шинэ мэдлэг бүтээж, шинэ санааг ундрааж, залуу үеийнхнийг сурган хүмүүжүүлж байдаг учраас Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж чадах юм. Тиймээс бодлогын зөвлөмжийн энэ дугаартаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд манай их, дээд сургуулиуд хэрхэн хувь нэмэр оруулах асуудлыг хөндөж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Зарим нэг Тогтвортой хөгжлийн зорилгод боловсрол, судалгааны ажлын ач холбогдлыг тодорхой заасан байдаг учраас эдгээр асуудлыг шийдвэрлэхэд их, дээд сургуулиудын үүрэг ихээхэн чухал юм. Гэхдээ их, дээд сургуулиудын үүрэг үүгээр хязгаарлагдахгүй, бүх зорилгыг хэрэгжүүлэхэд тэд бодьтой хувь нэмэр оруулах боломжтой. Их, дээд сургуулиуд нийгэмдээ нэр хүндтэй, итгэл хүлээсэн байдаг учраас нийт ард түмнээ тогтвортой хөгжлийн асуудлаар боловсролтой болгох, тэдэнд тогтвортой

хөгжлийн үзэл баримтлалыг таниулах тал дээр хамгийн чухал үүрэг хүлээдэг. Нөгөө талаас, их дээд сургуулиуд тогтвортой хөгжлийн асуудлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулснаар улс орныхоо хөгжил дэвшилд болон цаашилбал, дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэхэд оролцох боломж нээгдэнэ. Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд их дээд сургуулийн гол үүргийг дараах байдлаар тодорхойлж болно.

- 1 Их сургуулиуд нь шинэ мэдлэг, инновацийн шинэ санаа, шийдлүүдийг бүтээж, дээрх
- 2 Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх төрийн бодлогын хувилбаруудыг боловсруулж санал болгох, хэрэгжүүлэх
- 3 Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд бүх нийтээрээ оролцох ёстой учраас их сургуулийн өмнө ихээхэн хариуцлагатай үүрэг ногдож байдаг. Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд бодьтой хувь нэмэр
- 4 Тогтвортой хөгжлийн зорилгуудын ач холбогдол болон эдгээр зорилгуудыг хэрэгжүүлэхэд хувь хүн бүрийн

зорилгуудыг хэрэгжүүлэхэд дэм үзүүлэх ёстой.

арга зам, тодорхой шийдлүүдийг боловсруулж холбогдох газруудад нэвтрүүлэх боломжтой.

оруулах мэдлэг чадвартай ажил хэрэгч хүмүүс, ирээдүйн удирдагчид, шийдвэр гаргагчдыг бэлтгэх мэргэжлийн мэдлэг чадвар, харилцааны ур чадварыг боловсруулж, хэрэгжүүлж байх учиртай.

үүрэг оролцооны талаар олон түмэнд ойлгуулах, таниулах, тодорхой боловсрол олгох тал дээр идэвхтэй ажиллах ёстой.

Нөгөө талаас, тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх үйл хэрэгт их, дээд сургуулиуд идэвхтэй

оролцсоноор дараах үр ашгийг хүртэх болно.

Үүнд:

- 1 Их, дээд сургуулиудаас тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх талаар хийж байгаа ажил, түүний үр өгөөжийн талаар засгийн газар, нийгмийн янз

бүрийн давхарга, санхүүгийн дэмжигч зэрэг гаднын хамтран ажилладаг байгууллагуудад сурталчлах, танилцуулах улмаар тэдний дэмжлэг авах өргөн бололцоог нээж өгдөг.



2 Залуучууд болон ахмад үеийнхэн нийгэмдээ болон байгаль орчиндоо мэдэгдэхүйц хувь нэмэр оруулах санал санаачилгыг гаргах болж байна. Энэ үед тогтвортой хөгжлийн зорилгын талаар гүнзгий

мэдлэгтэй хүмүүсийг их, дээд сургуулиудаас хүлээх болж байна. Энэ нь их сургуулиудын сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлтийг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу хийх шаардлагатай болгож байна.

3 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын нэг давуу тал бол нэгдсэн ашиг сонирхлын дор хамтран ажиллах явдал

юм. Энэ нь их, дээд сургуулиудад шинэ хэлбэрийн хамтын ажиллагааг бий болгох, өргөжүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

4 Өнөөдөр их сургуулиуд өөрсдийн эрхэм зорилго, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ эргэн харах, 21-р зуунд нийгмийн өмнө тавигдаж байгаа асуудлуудад бодьтой, шинжлэх ухааны үндэстэй, баталгаа нотолгоонд тулгуурласан бодлогын шийдлийг боловсруулахад анхаарах болж байна. Энэ эрхэм

зорилгоо хэрэгжүүлэхэд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нэгдүгээрт, их сургуулийг дэлхий дахинаа танигдахад өөрийн сүлжээнүүдээр дамжуулан дэмжлэг үзүүлэх, хоёрдугаарт, тогтвортой хөгжлийн талаар олон улсын холбоо, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөл бололцоогоор хангаж өгнө.

Тогтвортой хөгжлийн асуудлаар их, дээд сургуулиуд ажиллаж эхлэхийн тулд дараах

үе шаттай арга хэмжээнүүдийг авбал зохино.

Үүнд:

1 Өөрийн их сургууль дээр тогтвортой хөгжлийн чиглэлд хийгдэж байгаа сургалт, судалгааны ажлуудын талаар мэдээллийг нэгтгэж, Монгол улсын тогтвортой хөгжлийн

үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд их сургуулиас хувь нэмэр оруулж байгаа болон оруулж болох чиглэлүүдийг нарийвчлан тодорхойлно.

2 Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд өөрийн сургуулийн дотоод

нөөц боломжийг дээшлүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй.

3 Тэргүүлэх чиглэлүүд болон тулгамдаж байгаа бэрхшээлтэй асуудлууд, шинээр


гарч ирж байгаа боломжуудын талаар тодорхой мэдээлэлтэй болох хэрэгтэй.

4 Их сургуулийн хөгжлийн стратеги, бодлого, төлөвлөгөөнд тогтвортой

хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмрээ нарийвчлан тодорхойлох хэрэгтэй.

5 Эцэст нь тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд их сургуулиас оруулж байгаа

хувь нэмрийг байнга үнэлж дүгнэж, сонирхогч талуудтай санал солилцож байх хэрэгтэй.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ИХ СУРГУУЛИУДЫН ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМРИЙН ТАЛААР ЖИШЭЭ БАРИМТ



ЗОРИЛГО 1 - ЯДУУРЛЫГ УСТГАХ

Үндэсний Статистикийн хорооны мэдээллээр Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 1995-2007 онд 36.3 хувиас 29.3 хувь болж ерөнхийдөө аажим буурсан боловч 2008-2009 онд 35.2 хувиас 38.7 хувь болж өссөн байна. Харин 2010-2014 онд 38.8 хувиас 21.6 хувь болж буурсан байна. Гэвч ядуурлын түвшин

2016 гэхэд эргээд 29.6 хувь болж нэмэгджээ. Энэ нь 2016 оны байдлаар нийт хүн ам болох 3 сая 63 мянган хүнээс 907.5 мянга нь ядууралд өртсөн байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, 2016 онд манай улсын 869.8 мянган өрхийн 22.1 хувь нь буюу 192.2 мянга нь ядуу өрх байна.

Баримт 1 – Чикагогийн их сургуулийн ядуурлын асуудал судлах лаборатори

2015 онд Чикагогийн их сургуулиас хотын хэмжээнд ядуурлыг бууруулахын тулд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхэд чиглэсэн судалгаанд үндэслэсэн бодлогыг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор ядуурлын асуудал судлах лаборатори байгуулжээ. Чикаго хотод хагас сая хүн ядууралд өртсөн байна. Орчин үеийн судалгааны аргуудыг хэрэглэн засгийн газрын байгууллагууд, ашгийн бус байгууллагуудтай хамтран эдийн засгийг өөд

нь татах хамгийн сайн хөтөлбөр, бодлогыг олж илрүүлэх улмаар нөөц бололцоог үр дүнтэй зарцуулж, ядуурлыг бууруулахад чиглүүлэх ажлыг хийж байгаа нь үр дүнд хүрч байна.

Манай орны хувьд хот хөдөөгийн ялгааг арилгах, ядуурлын учир шалтгааныг бодьтой тогтоож, түүнийг устгах чиглэлээр судалгаанд тулгуурласан бодлогын зөвлөмж гаргах талаар их сургуулиудын эрдэм шинжилгээний үйл ажиллагааг чиглүүлэх боломжтой.



ЗОРИЛГО 2 - ӨЛСГӨЛӨНГ ЗОГСООХ

Олон улсын хоол хүнсний бодлогын судалгааны хүрээлэнгээс дэлхийн өлсгөлөнгийн индексийг гаргажээ. 2017 оны энэхүү индексийн судалгаанд манай улс 57-д жагсжээ. 2000 онтой харьцуулбал манай орон өлсгөлөнд өртөх эрсдэлийг 50-аас дээш хувиар бууруулсан хэдий ч хоол хүнсний шим тэжээл муу, нярай хүүхдийн

эндэгдэл, биеийн жин, өндрийн хувьд өсөлт удаашралтай явагдах байдал ажиглагдсаар байна. Хүнсний аюулгүй байдал, сурагчдын үдийн хоол, хоол хүнсний шим тэжээлийн талаар ШУТИС болон бусад их сургуулиудаас явуулж байгаа судалгаа, туршилтын ажлыг цаашид дэмжиж, үр өгөөжийг нь үнэлж дүгнэх шаардлагатай байна.

Баримт 2 – Их сургуулиуд өлсгөлөнгийн эсрэг хөдөлгөөн

2004 онд Аубурн (Auburn) их сургууль Дэлхийн хүнсний байгууллагатай хамтран дэлхий дахины хамгийн тулгамдсан асуудал болж байгаа өлсгөлөнтэй тэмцэх хөдөлгөөнийг санаачилж, улмаар Их сургуулиуд өлсгөлөнгийн

эсрэг эвслийг 2006 онд байгуулсанд 300 гаруй их сургууль нэгдсэн байна. Энэ эвсэл нь оюутны санаачилсан богино хугацааны арга хэмжээнээс гадна сургалт эрдэм шинжилгээний урт хугацааны шийдлүүдийг эвсэлд нэгдсэн бусад



их сургуулиудад хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авч, төгсөгчдөө дэлхий нийтийн асуудлыг мэдэх төдийгүй, түүнийг шийдвэрлэхэд иргэний нийгмийн хүрээнд идэвхтэй байр суурьтай байх, их сургуулиуд дэлхий дахины тулгамдсан асуудал болох өлсгөлөнгийн эсрэг бүтээлч шинэ шийдлүүдийг бий болгоход манлайлах

үүрэгтэй оролцохыг дэмжих зорилготой ажээ. Тус эвслийн хүрээнд Өлсгөлөнгийн эсрэг бүтээлч шийдэл гаргах үүрэгтэй хүрээлэн байгуулж, шинэ санааг дэмжих, харилцан солилцох, шинэ мэдлэгийг хичээлд хэрэглэх зэрэг олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.



ЗОРИЛГО 3 - САЙН ЭРҮҮЛ МЭНД, САЙХАН АМЬДРАЛЫГ ДЭМЖИХ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэдээллээс үзэхэд 2016 оны байдлаар Монгол улсын хүн амын дундаж наслалт 69.57 байгаа ба эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.10, эрэгтэйчүүдийнх 65.58 байна. Олон улсын түвшинд 15 хүртэлх насны хүн амын эзлэх хувь 31 хувиас дээш байвал залуу хүн амтай улс орон гэж үздэг бол манай улсын хувьд энэ үзүүлэлт 30.0 хувь байна. 2016 онд улсын хэмжээнд 28 төрлийн халдварт өвчний 69'663 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 10'263 тохиолдлоор нэмэгдсэн буюу 10'000

хүн амд 227.8 байна. 10'000 хүн амд ногдох халдварт бус өвчлөл 8'245.4 байгаа ба үүнээс амьсгалын тогтолцооны өвчин 1'647.4, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1'231.4, шээс бэлгийн тогтолцооны өвчин 807.6, зүрх-судасны тогтолцооны өвчин 1'007.6, гэмтэл, хордлого ба бусад гаднын шалтгаант өвчин 469.9 ногдож байна. Хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулахад Анагаахын Шинжлэх ухааны Үндэсний их сургууль, Этүгэн их сургууль болон бусад их сургуулиудын оруулах хувь нэмэр, үүрэг хариуцлага их юм.

Баримт 3 - UNIVERSITAS 21 бүлэг

Судалгааны тэргүүлэх их сургуулиуд 1997 онд Австралийн Мельбурн хотноо цугларч Universitas 21 бүлгийг байгуулжээ. Тэдгээр судалгааны их сургуулиудын эрүүл мэндийн шинжлэх ухааны салбар сургууль, факультетын декануудаас бүрдсэн U21 анагаахын шинжлэх ухааны сүлжээг 2000 онд Сингапурт байгуулжээ. Өнөөдөр энэ сүлжээ 11 орны 18 их сургуулийг хамарч байдаг

бөгөөд Бирмингэмийн их сургууль дээр төвтэй ажээ. Энэ сүлжээ нь Тогтвортой хөгжлийн 3-р зорилгыг сургалтын нөөц материал боловсруулах, тогтвортой хөгжлийн 7 хоногийг зохион байгуулах, оюутны дадлага зохион байгуулах, жил бүрийн уулзалт зөвлөгөөн зохион байгуулах хэлбэрээр сурталчилж, түүний хэрэгжилтэд тодорхой хувь нэмэр оруулж байна.



ЗОРИЛГО 4 - ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлийг танин мэдэрч, шийдвэрлэх эр зориг, мэдлэг

чадварыг оюутан залуучуудад суулгахад их дээд сургуулиуд анхаарах ёстой.

Үүний тулд:

- Оюутан залуучуудад улс орныхоо тогтвортой хөгжлийг хангах ажилд идэвхтэй оролцогч байхын тулд системийн сэтгэлгээ, өөрийгөө таних, асуудлыг шийдвэрлэх арга барил, ирээдүй судлал, эрх зүйн хэм хэмжээ

тогтоох, стратеги тодорхойлох чадамж зэрэг 21-р зууны чадамжийг эзэмшүүлэх, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, зорилго, зорилтуудыг ойлгож, өөрийн орны нөхцөл байдалд тусгах мэдлэг чадварыг эзэмшүүлэх шаардлагатай.

- Их, дээд сургуулиуд сургалтын төлөвлөгөөндөө тогтвортой хөгжлийн зарчмыг бүрэн тусгах, тогтвортой хөгжлийн мэдлэг чадварыг олгох сургалтыг сургалтын албаны мэргэжилтнүүд болон багшийн хөгжлийн төвийн ажилтнууд болон гаднын байгууллага

- Түүнээс гадна их, дээд сургуулиуд нээлттэй, онлайн хичээлийг олноор бэлтгэж, бүх нийтэд, ялангуяа залуучуудад насан

- Их, дээд сургуулиуд өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааран 150'000 гаруй залуучуудтай тулж ажилладаг учраас энэ боломжийг ашиглан оюутан залуучуудад тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хичээлээс гадуур залуу лидер бэлтгэх хөтөлбөр, инновац зохион бүтээх дугуйлан,

- Их, дээд сургуулиуд нийгмийн тулгамдсан асуудлуудад уян хатан, хурдан шуурхай хандаж, ирээдүйд чиглэсэн

- МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030-д тусгагдсан “Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын

хүмүүст зохион байгуулах, боловсролын талаар төрийн бодлогод тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусгах талаар зөвлөмж өгөх зэрэг өргөн хүрээтэй бодит үйл ажиллагааг явуулснаар чанартай боловсрол олгох зорилгыг хэрэгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулах юм.

туршийн боловсрол олгох тогтолцоог бий болгоход онцгой анхаарах хэрэгтэй.

оюутны холбоо, төрөл бүрийн клубүүдээр дамжуулан ойлгуулж мэдрүүлж, тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх талаар тэдний санаачилга, сайн дурыг хөдөлгөөнийг бүх талаар дэмжиж, олон улсын сүлжээтэй холбон өгч урам зоригийг нь дэмжих хэрэгтэй.

мэргэжилтэн бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэдлэг ур чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд онцгой анхаарвал зохино.

тогтолцоог боловсронгуй болгоно” гэсэн зорилт 4, түүнийг хэрэгжүүлэхэд бодтой хувь нэмэр оруулах талаар их, дээд сургуулиуд төлөвлөгөөтэй ажиллах нь зүйтэй.

Баримт 4 – Academic Impact санаачилга

НҮБ-ын зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, дэмжихэд их, дээд сургуулиудын үйл ажиллагааг ойртуулах зорилготой энэ сүлжээнд дэлхийн 130 орны 1'300 их, дээд сургуулиуд нэгдэн оржээ. Манай орноос МУИС, Монголын Олон улсын их сургууль гишүүнээр нэгдсэн байна. Эдгээр их сургуулиудын үйл ажиллагаа нь тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд шинэ санааг бойжуулах инкубатор болох, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдэхэд нээлт бүтээл

гаргах, шийдэл олох зэргээр чухал үүрэгтэй. Энэ санаачилгын хүрээнд Обамагийн сангийн тэтгэлэг, манлайлагч оюутан залуучууд зэрэг тэтгэлэг олгохоос гадна НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудад дадлага хийх боломжийг олгодог байна. Мөн энэ сүлжээнээс тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх талаар бусад орны их дээд сургуулиудын туршлага, төсөл санаачилгын талаар мэдээллийг олж авч болно.



ЗОРИЛГО 5 - ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

2015 онд IRIM судалгааны хүрээлэнгээс гаргасан “Монгол улс дахь жендерийн тулгамдсан асуудлууд” тайлангаас үзэхэд манай улсад жендерийн тэгш байдлыг хангахад шаардлагатай

эрх зүйн орчин харьцангуй хүчтэй бүрдсэн боловч гэр бүлийн хүчирхийлэл, цалин хөлсний ялгаатай байдал тулгамдсан асуудал хэвээр байна. Түүнээс гадна эрэгтэйчүүдийн эрүүл мэнд



доройтох үзэгдэл анхаарал татах болж байна. НҮБХХ-өөс жил бүр гаргадаг хүний хөгжлийн статистик үзүүлэлтийн дотор жендерийн хөгжил, жендерийн тэгш бус байдал гэсэн 2 үзүүлэлтийг тусгайлан авч үздэг бөгөөд 2017 оны байдлаар Монгол улс жендерийн хөгжлийн үзүүлэлтээр

1-р бүлэг улсад хамрагдсан бол жендерийн тэгш бус байдлын үзүүлэлтээр 66-д жагссан байна. Их, дээд сургуулиудын хүмүүнлэг, нийгмийн ухааны судалгааг жендерийн асуудалд чиглүүлж ажиллуулбал зохино.

Баримт 5 – Бристолын их сургуулийн Жендерийн асуудал судлах төв

Бристолын их сургуулийн Жендерийн асуудал судлах төвөөс Их Британи болон дэлхий дахинаа жендерийн тэгш бус байдал оршин тогтнож байгаа учраас түүнийг илрүүлэх, судлах, жендер ба эрх мэдлийн асуудлыг эргэж харах чиглэлээр судалгааны ажил явуулж, бакалавр, магистрын зэрэг олгох нэр хүндтэй сургалт явуулж,

докторын судалгаа, зөвлөх үйлчилгээг өндөр түвшинд явуулдаг байна. Тухайлбал, 2016 онд тус төвийн профессор Сара Чайлдс Их Британий парламентын жендерийн тэгш бус байдалд дүн шинжилгээ хийж “Сайн Парламент” гэсэн зөвлөмжийг гаргасан нь улс орон даяар нэлээд шуугиан тарьсан судалгааны ажил болжээ.



ЗОРИЛГО 6 - БАТАЛГААТАЙ УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ

2018 оны 4-р сард манай улсад ажилласан Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Лео Хеллер манай улсад хүний хэрэглээнд зориулсан ундны усыг иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмж, мөн бие засах газар ба халуун усанд орох, хувийн ариун цэврийг сахих газар зэрэг ариун цэврийн байгууламжуудын хүртээмжийн асуудалтай танилцаад 2015 оны байдлаар, нийт хүн амын зөвхөн дөрөвний нэг хэсэг нь гэртээ цоргоноос ус авдаг гэсэн бол дөнгөж 13 хувь нь л бохир усны нэгдсэн сүлжээнд холбогдсон байна гэсэн баримт байгаа нь Засгийн газар, мэргэжлийн байгууллагуудын анхаарах асуудал мөн гэж тэмдэглэжээ. Түүнээс гадна ундны ус, ариун цэврийн байгууламжийн

үйлчилгээний хүртээмж хот, хөдөөд тэгш бус байна. Тухайлбал, хотуудад оршин сууж буй иргэд бараг бүгд (94 хувь нь) ундны усаар хангагдаж байгаа бол хөдөөгийн хүн амын зөвхөн тал нь (56 хувь) ийм түвшний үйлчилгээг авч байна. Ариун цэврийн байгууламжийн хувьд ч хот, хөдөөгийн ялгаа их буюу хотын хүн амын 66 хувь нь энгийн ариун цэврийн байгууламжтай байгаа бол хөдөөд зөвхөн 41 хувь нь бие засах газартай байна. Орон сууцны нэг өрх өдөрт дунджаар 200 литр ус хэрэглэдэг бол гэрт амьдардаг өрхийн нэг гишүүн өдөрт 7-15 литр ус хэрэглэдэг гэсэн тооцоо байна. Ийм нөхцөлд их сургуулиуд, ялангуяа инженерийн чиглэлийн их дээд сургуулиуд энэ чиглэлээр оновчтой шийдэл гаргах, шинэ бүтээл зохиох, нэвтрүүлэх чиглэлээр ажиллавал зохино.

Баримт 6 – Манитобагийн их сургууль –тогтвортой хөгжлийн 6-р зорилгын төв цэг

29000 оюутантай, 5000 багш эрдэм шинжилгээний ажилтантай Манитобагийн их сургууль нь Канадын судалгааны тэргүүлэх их сургуульд ордог бөгөөд нутгийн уугуул иргэдийн талаар бодтой хувь нэмэр оруулсан их сургууль

юм. Энэ их сургууль нь усны чанар, үерийн аюул, ган гачигаас урьдчилан сэргийлэх, усны бохирдолтын асуудлыг судалж, энэ чиглэлээр шинэ мэдлэг, технологи бүтээж, нэвтрүүлж байна.

Баримт 6а – Стэнфордын оюутны бүтээл

Хүний биеийн ялгадсыг цэвэр орчинд тусгаарлаж хаях явдал бол эрүүл мэндийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, хувь хүний ариун цэврийг хамгаалах ач холбогдолтой. Харамсалтай нь хөдөө орон нутагт энэ асуудал тулгамдсан хэвээр байна.

Стэнфордын их сургуулийн доктор оюутан найз нартайгаа хамтран старт-ап баг байгуулж, хямд үнэтэй контейнер бүхий хуурай бие засах газар бүтээж, улмаар Гайти улсын 2 мужид туршсан нь их амжилттай болжээ.



ЗОРИЛГО 7 - ХЯМД, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Монгол улсын эрчим хүчний систем нь нийт хүн амын 80%-ийг эрчим хүчээр хангадаг бөгөөд улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой байдалд ихээхэн нөлөө үзүүлдэг салбар юм. Үйлдвэрлэж буй цахилгааны 80%-нь нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцуудаас хангагдаж байдаг бол 4%-нь дизелийн станц, 3 хувь нь сэргээгдэх эрчим хүч, үлдсэн 13%-ийг гадаадаас, гол

төлөв ОХУ-аас импортоор авдаг байна. Цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, эрчим хүчний алдагдлыг бууруулах, нүүрснээс хий гаргах, шингэрүүлэх зэрэг дэвшилтэт технологийг бий болгох нэвтрүүлэх, ус салхи нарны эрчим хүчийг түлхүү хэрэглэх талаар инновац, шинэ санаа, бүтээл гаргах талаар их сургуулиуд идэвхтэй ажиллах хэрэгтэй байна.

Баримт 7 – Тель-Авивын их сургуулийн Сэргээгдэх эрчим хүчний төв

Шинэ үр дүнтэй сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бий болгох талаар ажилладаг Тель-Авивын сэргээгдэх эрчим хүчний төвийн захирал Ёси Розенбах улс орноо хөрш орнуудын газрын тос, байгалийн хийгээс хамааралтай байдлаас гаргах арга зам бол цэвэр эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэх явдал гэж үзээд тус их сургуулийн 300 эрдэмтдийг 55 судалгааны баг

болгон энэ чиглэлээр ажиллуулж байна гэжээ. Эрчим хүч хадгалах, нарны эрчим хүч, биомассын чиглэлээр хамгийн сүүлийн үеийн технологи бүхий лаборатори байгуулан ажиллуулж байгаагийн дээр цахилгаанаар ажилладаг машин бүтээх төслийг хэрэгжүүлж байна.



ЗОРИЛГО 8 - ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

2016 оны байдлаар эдийн засгийн идэвхтэй хүн ам 1275.7 мянга байгаагийн 39.7%, хөдөлмөр эрхэлж буй 1147.8 мянган ажиллагчид байгаагийн 40.5% нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Ажилгүйдлийн түвшин 9.1% болж өссөн байна. 2015-2016 онд явуулсан “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-наас үзвэл барилга, архитектурын мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр буюу 83.2%

байгаа бол нийгмийн халамж, биеийн тамир, спортын мэргэжлийн чиглэлээр төгсөгчид хамгийн бага буюу 50% нь хөдөлмөр эрхэлж байна. Энэ байдлаас үзвэл их, дээд сургуулиуд юуны өмнө төгсөгчдөө зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг чадвар, ялангуяа харилцааны соёл, бүтээлч сэтгэхүй, бие даан ажиллах чадвар зэрэг 21-р зууны чадавхыг эзэмшүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.



Баримт 8 – The Global Labour University

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэй Дэлхий дахины Хөдөлмөрийн их сургуулийг Герман, АНУ, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс, Энэтхэг улс санаачлан 2002 онд байгуулсан бөгөөд Бразил дараа нь нэгдсэн байна. Дээрх улсуудын үйлдвэрчний холбоод, их сургуулиуд хамтран энэ сүлжээний хүрээнд

нэг жилийн хугацаатай магистрын сургалт явуулж, гишүүн орнуудынхаа үйлдвэрчний байгууллагуудын чадавхыг дээшлүүлэхийн сацуу судалгааны ажил явуулж, туршлага солилцож, хамтарсан эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн зохион байгуулдаг байна.



ЗОРИЛГО 9 - ИННОВАЦ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

НҮБ-ын дэргэдэх оюуны өмчийн агентлагаас гаргадаг “Дэлхийн Инновацийн Индекс” тайланд дэлхийн 126 орныг 80 үзүүлэлтээр дүгнэж, эрэмбэлсэн байна. Гар утасны аппликэйшн бүтээхээс эхлээд боловсролд зарцуулж буй хөрөнгө, шинжлэх ухаан, технологийн судалгааны нийтлэлүүд, оюуны өмч бүртгүүлэх хэмжээ зэрэг үзүүлэлтүүд үүнд багтдаг. 2018 онд манай улс 53-р байрт орсон байна. Манай орны их, дээд сургуулиуд инновацыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллаж байна. Тухайлбал, ШУТИС 2021 он

хүртэл инновацын чиглэлээр шат дараалсан арга хэмжээ төлөвлөжээ. Давост болдог Дэлхийн Эдийн засгийн форумын үеэр технологиор баялаг эдийн засгийн нөхцөлд их сургуулиуд инновацыг хөгжүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх катализатор байхыг чухалчлан заажээ. Үүнд хүрэхийн тул их сургуулиуд хувийн сектортой хамтран ажиллах, ухаалаг хамт олныг дотоод гадаадаас бүрдүүлэх, технологийг нийгэмд хэрэглэх арга замыг хайхад түлхүү анхаарах хэрэгтэй гэжээ.

Баримт 9 – Лундын их сургуулийн инновацийн төв

Лундын их сургуулийн инновацийн лаборатори нь багш, оюутны судалгааны ажлын үр дүн, шинэ санааг шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга барил болгон арилжаанд оруулж тусалдаг байна. Энэ төв нь патентын зөвлөгөө өгч, төслийг санхүүжүүлж, хуулийн


болон гэрээний асуудлаар зөвлөгөө өгч шинэ санааг бизнес болгон хөгжүүлэхэд тусалдаг байна. Өнгөрсөн хугацаанд 90 шинэ компани байгуулахад хөрөнгө оруулалт хийж, 1 тэрбум швед кроны татварын орлого оруулсан байна.



ЗОРИЛГО 10 - ТЭГШ БИШ БАЙДЛЫГ БУУРУУЛАХ

“Foreign Policy” сэтгүүл болон “Америкийн Энх тайвны сангаас” хамтран гаргадаг “Fragile State Index” буюу “Улсын эмзэг байдлын индекс”-ээр Монгол Улс 2017 оны чансаанд 56.70 оноогоор 178 орноос 128 дугаар байрт жагсаж байна. Энэ үзүүлэлт нь тус индексийн хувьд “тун эмзэг” хэмээх ангилалд багтаж байгаа юм. Түүнчлэн манай улсад баян, ядуугийн ялгаа улам ихсэж байна. Олон улсад баян, хоосны ялгааг хэмждэг “Gini Index”-ийг Дэлхийн банк жил бүр гаргадаг. Уг индекс улс орнуудад харилцан адилгүй байдаг ч жилийн үзүүлэлтээрээ өсөж, буурсан байдаг бол манай улсын хувьд 2000 оноос хойш тогтмол өсжээ. 2015 оны НҮБ-ын Хөгжлийн

Хөтөлбөрөөс хийсэн судалгаанд Монголын хүн амын 21.6 хувь нь нэн ядуу, 42.04 хувь нь бага орлоготой, 36.08 хувь дундаж давхаргад хамаарч байна гэсэн бол 0.28 хувийг баячууд эзэлдэг гэсэн тооцоолол гаргасан байдаг. Үүнээс эргэцүүлэн харвал монголын нийгэм баян, ядуу гэсэн хоёр хэсэгт л хуваагдахаар эрчимтэй тэмүүлж буй нь тодорхой байна. Oxfam олон улсын байгууллагаас гаргадаг жил бүрийн тайлангаас үзвэл 2016 онд дэлхий дахинаа бүтээгдсэн баялгийн 82% -нь дэлхийн хамгийн баян 1%-д очсон байхад дэлхийн хүн амын 50% болох хамгийн ядуу 3.7 тэрбум хүн юу ч хүртээгүй байна. Манай оронд ч гэсэн нийгмийн



тэгш бус байдлын талаар ул үндэстэй судалгаа, түүнийг бууруулах талаар жинтэй зөвлөмжийг

их, дээд сургуулиудаас хүлээсээр байна.

Баримт 10 – Нийгмийн ухааны дэлхийн тайлан

2016 онд ЮНЕСКО-оос Нийгмийн ухааны дэлхийн ээлжит тайлангаа гаргасан юм. Энэ тайлангийн гол дүгнэлтүүд нь гэвэл дэлхийн олон оронд эдийн засаг, улс төрийн эрх мэдэл ба нөөц цөөхөн хүний гарт орж байгаагаас эрүүл ардчилалд аюул тулгарч, эдийн засаг, нийгмийн тэгш бус байдал газар авч байна. Хятад, Энэтхэг улсын эдийн засгийн өсөлт, хөгжилтийн үр дүнд 2000 оны эхний арван жилд тэгш бус байдал буурсан мэт харагдаж байгаа боловч, хөгжиж

байгаа болон буурай хөгжилтэй орнуудад тэгш бус байдал сайжраагүй байна. Тэгш бус байдал, нийгмийн шударга ёсны талаарх судалгааны ажил, нийтлэлийн тоо 1992 оноос хойш 5 дахин өссөн боловч, тэдгээрийн 80%-нь Хойд Америк, Европын эрдэмтдийн бүтээл байна. Хөгжиж буй орнуудын эрдэмтдийн энэ чиглэлээр явуулж байгаа судалгааг бүх талаар дэмжих шаардлагатай байна.



ЗОРИЛГО 11 - ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ

Азийн Цагаан дагина гэж нэрлэгдэж байсан Улаанбаатар хот өнөөдөр 1.4 сая хүн амтай болж сүүлийн 20 жилийн дотор хотын хүн ам 118%-аар өссөн байна. Түүнээс гадна Улаанбаатар хотын агаарын бохирдол жилээс жилд нэмэгдэж, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Өөр нэг бэрхшээл бол автомашины түгжрэл юм. Их дээд сургуулиуд Улаанбаатар

хотын хамгийн том сектор учраас оршин сууж байгаа хотынхоо тулгамдсан асуудлыг шийдэх талаар санаачилгатай ажиллаж, хотын удирдлагатай хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулж, тодорхой асуудлаар судалгаа хийж, сургалт явуулж, ул үндэстэй зөвлөмж гаргаж өгөх шаардлагатай байна.

Баримт 11 – Саутамптоны их сургууль

Саутамптон хот бол их Британий хамгийн их агаарын бохирдолтой хот юм. Үйлдвэрийн газруудын утаа, хорт хий нь хот дотор болон эргэн тойронд амьдарч байгаа хүмүүсийн эрүүл мэндэд эрсдэл учруулж, бизнес, төрийн байгууллага, оршин суугчдын тав тухыг алдагдуулж байжээ. Одоо ашиглаж байгаа агаарын чанарыг шалгах арга зүй нь эх үүсвэрээс нь 1 км-ийн дотор хуримтлагдсан агаарын бохирдолтыг тодорхойлох боломжгүй юм. Энэ хотод дэлхийн

100 топ их сургуульд багтдаг Саутамптоны их сургууль байдаг бөгөөд хотын захиргаатай хамтран агаарын бохирдлын урсгалыг тодорхойлох компьютерын загварчлалыг зохиож, салхи, усны хонгил, лазерын технологид тулгуурласан агаарын урсгалыг хэмжих багаж хэрэглэн загвар бүтээсэн нь агаарын бохирдолтын хэмжээ, урсгал хөдөлгөөний талаар бүрэн мэдээлэлтэй болж, түүнийг арилгах арга хэмжээ авах боломжтой болгожээ.



ЗОРИЛГО 12 - ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ

Бид идэж, хэрэглэж, өмсөж байгаа зүйлээ хир хэмжээндээ тохируулахгүй байгаагаас шалтгаалаад дэлхийн уур амьсгал өөрчлөгдөн, дэлхийн дулааралт явагдаж, байгаль орны

тогтвортой байдал алдагдаж, газрын доорх болон дээрх усны чанар муудаж, нөөц багасах зэрэг дэлхийн хэмжээний өөрчлөлтүүд гарч байна. Монгол улсын үндэсний статистикийн



хорооноос гаргасан мэдээллээр хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент 2017 оны 4 дүгээр улиралд Зүүн бүсэд 0.360, Улаанбаатар хотод 0.368 болж, улсын дунджаас 0.009-0.017 нэгжээр их, Баруун, Хангай, Төвийн бүсүүдэд 0.316-0.329 болж, улсын дунджаас 0.022-0.035 нэгжээр бага байна.

Улсын дунджаар Жини коэффициент өмнөх оны мөн үеэс 0.002 нэгжээр, өмнөх улирлаас 0.011 нэгжээр нэмэгдсэн байна. Орлогын ялгаатай бүлэг доторх болон бүлэг хоорондох тэгш бус байдлыг харуулах Тейлийн индекс 2017 оны 4 дүгээр улиралд 0.212 болж, өмнөх оны мөн үеэс 0.017 нэгжээр буурч, өмнөх улирлаас 0.003 нэгжээр нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд 2017 оны 4 дүгээр улиралд хамгийн ядуу бүлгийн хүн амын хэрэглээ нийт хэрэглээнд 7.2 хувийг, хамгийн чинээлэг бүлгийн хүн

амын хэрэглээ 42.0 хувийг эзэлж байна. Энэ нь хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээний дундаж хэмжээ хамгийн ядуу 20 хувийнхнаас 5.8 дахин их байгааг харуулж байна. Дэлхийн банкны мэдээллийн баазаас үзвэл монголчуудын хамгийн их хэрэглээ нь хүнс, ундаа, түүний дараа хувцас орж байна. Энэ хоёрт нийт хэрэглээний 55%-аас дээш хувь нь ногдож байна. Хариуцлагатай хэрэглээний асуудлаар их дээд сургуулиуд олон нийтийн дунд сурталчилгаа ухуулга явуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрдэмтдийн ярилцлага, зөвлөмжийг өргөн хүрээтэй явуулахаас ажлаа эхэлбэл зүгээр. Цаашилбал, эрүүл хүнс, зохистой хэрэглээ зэрэг цуврал хичээл явуулж, өрхийн орлого зарлагын тооцоо хөтлөх, өрхийн төсвийн төлөвлөлтийг зөв хийх, зөв зарцуулах талаар зөвлөмж гаргаж сурталчилбал зохино.

Баримт 12 – Хариуцлагатай хэрэглээ судлах хүрээлэн

Манчестерийн их сургуулийн хариуцлагатай хэрэглээний судалгааны хүрээлэнгээс Шотландын Засгийн газарт зориулж, хариуцлагатай хэрэглээг дэмжих зорилгоор хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчлөх талаар цоо шинэ хандлагын талаар баталгаа нотолгоонд тулгуурласан тайлан, зөвлөмжийг гаргаж өгчээ. Хариуцлагатай хэрэглээг дэмжих судалгааны уламжлалт арга нь хэрэглэгчийн сонголтод нөлөөлөхөд чиглэдэг


бол энэ шинэ арга нь “нийгмийн хандлага”-д тулгуурладаг байна. Хүмүүсийн өдөр тутмын нэг хэвийн амьдрал нь хэрэглэгчийн сонголтыг хязгаарладаг бөгөөд нийгмийн янз бүрийн бүлгийн хэрэглээний хэв маяг нь юуны өмнө тэдний өдөр тутмын ажил, амьдралын тогтсон хуваариас ихээхэн хамаардаг байна. Тиймээс хэрэглээг хариуцлагатай болгохын тулд тодорхой зөвлөмжийг энэхүү тайландаа гаргаж өгчээ.



ЗОРИЛГО 13 - УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ

Өнөөдөр уур амьсгалын өөрчлөлт нь Монгол нутагт дэлхийн дунджаас хэд дахин эрчимтэй явагдаж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ган зуд, байгалийн элдэв гамшгийн улмаас биологийн янз байдлын хомсдол, бэлчээрийн талхагдал, цөлжилтийн үйл явц хурдсаж асар олон гол ус, нуур цөөрөм, булаг шанд ширгэж алга болж байна. Мөн гүний усны хомсдол бий болж байна. Тухайлбал, Улаанбаатар хот орчмын гүний ус 10 жилд 4 метрээр доошилсон байна. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал бол нэг улсын хил хязгаараар тогтдоггүй учраас олон

улсын түвшинд өөрийн орны хэмжээнд явуулж байгаа судалгаа шинжилгээний ажлаа идэвхтэй сурталчлах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх талаар хамтын ажиллагаагаа өргөжүүлбэл зохино. Малын тоо толгой өссөнтэй холбогдуулан бэлчээрийн даац, ургамлын гарц зэрэг олон талын хүчин зүйлүүдийг хамруулсан загварчлалыг зохиож, төрийн бодлогын тодорхой зөвлөмж, малчдад зориулсан бодьтой судалгаанд үндэслэсэн гарын авлага бэлтгэж сургалт явуулах зэрэг олон талт ажлыг санаачилж болох юм.



Баримт 13 – Колумбийн их сургуулийн уур амьсгалын хүрээлэн

Хөгжиж байгаа орнуудын хүнамын амьдралын түвшнийг дээшлүүлэхийн тулд уур амьсгалын өөрчлөлт, үр нөлөөг таньж мэдэх, тааж мэдэх, зохицон амьдрах чадавхыг дээшлүүлэхийн тулд шинжлэх ухаанд тулгуурлан мэдээ, мэдээлэл, арга ухааныг хүмүүст нээлттэй, хүртээмжтэй болгохын тулд энэ хүрээлэн ажилладаг байна. Тус хүрээлэнгээс хэрэгжүүлж байгаа нэг томоохон сонирхолтой төсөл бол уур амьсгалын

өнөөдрийн болон ирээдүйн өөрчлөлтөд хөдөө аж ахуйг дасан зохицуулж өөрчлөх талаар Этиоп, Сенегал, Колумб, Гватемал, Бангладеш, Вьетнам зэрэг 6 улсад хэрэгжүүлж байгаа шинэ мэдлэгийг бүтээх, түүнийгээ бодит амьдрал дээр буулгах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үр өгөөжийг нь ашиглах гэсэн хэмнэлээр хэрэгжиж байгаа судалгааны төсөл юм.



ЗОРИЛГО 15 - ХУУРАЙ ГАЗРЫН ЭКО СИСТЕМИЙГ ХАМГААЛАХ

Монгол улсын газрын нөөц 156.4 сая га бөгөөд түүний 82 орчим хувийг тал хээр нутаг эзлэх бөгөөд энэ нь цөлөрхөг хээр, уулын ойт хээр зэрэг өргөн уудам экосистем бүхий дэлхийд хамгийн том үргэлжээр үлдсэн бэлчээрийн газарт тооцогдоно. Өнгөрсөн 30 орчим жилд хүний үйл ажиллагаа болон байгалийн нөлөөллийн хам хүчин зүйлийн улмаас газрын чанар доройтох, тухайлбал, бэлчээрийн даац хэтрэх, газрыг уламжлалт хэрэглээнд эрчимтэйгээр ашиглах

үед авах хамгаалалтын арга хэмжээ сул байгаа зэргээс энэхүү нөөц баялагт учрах аюул улам бүр нэмэгдсээр байна. Их, дээд сургуулиудын геоэкологийн салбаруудаас монгол орны экосистемийн нарийвчилсан судалгааг хийж, тогтвортой хөгжлийн загвар, зөвлөмж гаргах, хуурай газрын экосистемийг хамгаалах талаар эрх зүйн орчныг сайжруулах талаар тодорхой зөвлөмж гаргаж өгөх шаардлагатай.

Баримт 15 – Утрихтын их сургуулийн Коперникийн тогтвортой хөгжлийн судалгаа

2011 болон 2015 онд Утрихтын их сургууль тогтвортой хөгжлийн судалгааны үр өгөөжөөр Харвард, Стэнфордын их сургуулийг ардаа орхиж, хамгийн их нөлөөтэй судалгаа хийдэг их сургуулиар шалгарчээ. Энэ хүрээлэнгээс хуурай газрын ашиглалтын өөрчлөлт нь экосистемд хэрхэн нөлөөлөхийг судлахаас гадна түүний сөрөг үр нөлөөг бууруулах удирдлагын системийг зохион бүтээх, хуурай газар, ой мод, чийглэг газрын эко систем биологийн төрөл зүйлийн

талаар өөрчлөлтийг загварчлан судалдаг байна. Байгалийн баялгийн орон нутгийн удирдлагын оновчтой бүтцийг бий болгох, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх арга замыг олоход судалгааны ажлаа чиглүүлж байна. Түүнээс гадна хуурай газрын ашиглалтыг уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан зохицуулах, цөлжилтийн эрсдэлийг таамаглаж, ойн түймрийн аюулыг урьдчилан зайлуулах чиглэлээр ажилладаг байна.



ЗОРИЛГО 16 - ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ

Тогтвортой хөгжил нь энх тайван, шударга ёсыг эрхэмлэхгүйгээр хэрэгжих боломжгүй юм. Мөргөлдөөн, хүчирхийлэл, гэмт хэрэг, авлига зэрэг нь хэдэн зуун мянган тэрбум доллароор хэмжигдэх хөрөнгийг хөгжлийн үйл хэрэгт зарцуулахаас холдуулж байна. “Транспэрэнси

Интернэшнл” байгууллагаас гаргасан 2017 оны “Авлигын төсөөллийн индекс”-ээс үзвэл дэлхий нийтээр авлигатай тэмцсээр байгаа хэдий ч ихэнх улс орнуудын ахиц дэвшил хэт удаан байна. Судалгаанаас харахад авлигатай тэмцэх үйл ажиллагаанд дийлэнх орнуудад сүүлийн



6 жилд ахиц дэвшил гараагүй гэж дүгнэжээ. Монгол Улсын хувьд авлигын индекс 2015 онд 39 оноотой 72, 2016 онд 38 оноотой 87, 2017 онд 36 оноотой 103 дугаарт жагссан байна. Өөрөөр хэлбэл, манай улс 2017 онд 36 оноо авч, өмнөх оныхоос 16 байраар ухран 180 орноос 103 дугаарт эрэмбэлэгджээ. Монгол Улсын авлигын төсөөллийн индекс буурахад нөлөөлсөн

шалтгаан нь төрийн институциуд болох аудит, шүүхийн байгууллагуудын хараат бус байдал суларч байгаа нь сөргөөр нөлөөлсөн. Авлигын томоохон хэргүүдийн шийдвэрлэлт удааширч, ял шийтгэлгүй өнгөрөх, авлигын улмаас улсад учирсан хохирол эргэн төлөгдөхгүй байгаа нь нийгэмд авлигын эсрэг тэмцэлд иргэдийн итгэл сулрахад нөлөөлсөн хэмээн үзжээ.

Баримт 16 – Авлигын эсрэг тэмцэлд их сургуулиудын оруулах хувь нэмэр

Дэлхийн эдийн засгийн форумын үеэр болсон хэлэлцүүлэгт авлигын эсрэг тэмцэлд их сургуулиудын гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгсөн байна. Ирээдүйн лидерүүдийг бэлтгэдэг асар том бүтцийн хувьд их сургуулиуд авлигын эсрэг 5 үндсэн чиглэлээр ажиллах боломжтойг тодорхойлжээ. Нэгд, их сургууль дотооддоо авлигын эсрэг хөдөлгөөн өрнүүлж, аливаа тендерийг өрсөлдөөний үндсэн дээр шударгаар явуулах, багш ажилтан ажилд авахдаа неопотизмын эсрэг зогсох, шалгалт шүүлгийн дүнг мөнгөөр хаах зэрэг авлигын аливаа илрэлүүдийг таслан зогсоох талаар шийдэмгий арга хэмжээ авах хэрэгтэй. Хоёрт, оюутан залуучуудад ёс суртахууны сургалт явуулж, мэдлэг олж авахын төлөө бүхий л хүч чармайлтаа зориулж улс эх орондоо идэвхтэй шударга иргэн бэлтгэхэд анхаарах ёстой. Шалгалт, шүүлгийг “аргалах” арга барилтай оюутан бол ирээдүйд үнэнч шударга бус иргэн болох магадлал өндөр учир түүнийг эртнээс ойлгуулах хэрэгтэй. Мөн төслийн даалгавар, бичгийн ажил, эрдэм шинжилгээний ажил, диссертацийг бусдын ажлаас хуулахаас хамгаалж, жинхэнэ эрдмийн ордон болгоход ихээхэн анхаарах хэрэгтэй. Гуравт, ёс суртахууны хичээл бол оюутан залуучуудыг авлигын талаар мэдлэгтэй болгож, тэднийг ёс суртахууны тэгш

хүмүүжилтэй болгоход тус дэм үзүүлдэг. Гэхдээ сургуулиа төгссөний дараа ажил дээр гарах үед авлигаас гарах аргагүй байдалд орж мэдэх учраас тусгайлсан нэмэлт сургалтыг амьдралын практик нөхцөл байдал дээр явуулах нь тэднийг өв тэгш хүмүүжилтэй иргэн болоход их ач холбогдолтой. Дөрөвт, авлигын эсрэг бизнесийн тоо баримтыг ил тод болгож, ирээдүйн менежер, мэргэжилтнүүдийг авлигаас холдуулах арга замыг зааж өгөх хэрэгтэй. Тухайлбал, бүрэн бүтэн бус мэдээлэл, эрсдэлийн талаар тодорхой бус танилцуулга зэрэг нь авлигад түлхэх шалтаг болдог. Иймд бодит амьдрал дээр мэдээллийг ил тод, бүрэн бүтэн бий болгож, өртөг, эрсдэлийн талын нарийн мэдээллээр хангаж байвал авлигад өртөх үндэсгүй. Эцэст нь их сургуулиуд бусад байгууллагуудтай хамтран авлигын эсрэг хамтарсан арга хэмжээ зохиох нь ихээхэн үр дүнтэй болно. Дороос дээш чиглэсэн хамтын хүч чармайлт бол Засгийн газрын дээрээс доош чиглэсэн арга хэмжээ амжилтад хүрэхгүй байхад илүү үр дүнд хүрдгийг Нобелийн шагналт Элинор Остром хэлсэн байна. Иймд авлигатай тэмцэхэд их сургуулийн үүрэг их чухал юм.



ЗОРИЛГО 17 - ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ

Монгол улс Олон улсын Валютын сан болон олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр нийгмийн тогтвортой байдлыг баталгаажуулах макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг сэргээн тогтоох чиглэлээр ажиллаж байна. Цаашдаа хурдацтай, хүртээмжтэй тогтвортой өсөлтийг хангахуйц эдийн засгийн дархлаа, бүтцийг бий болгоход анхаарч

ажиллах шаардлагатай. Үүний тулд хөгжлийн түншүүдтэй нягт уялдаатай ажиллах шаардлага гарч ирж байна. Их дээд сургуулиуд гадаад харилцааныхаа үндсэн чиглэлийг тогтвортой хөгжлийг дэмжих чиглэл рүү хандуулах нь манай орны төдийгүй хамтын ажиллагаатай улс орнуудын хувьд чухал ач холбогдолтой болно.

Баримт 17 – “Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь” – Их сургуулиудад зориулсан гарын авлага

Дэлхий дахинаа тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд их сургуулиуд чухал үүрэг гүйцэтгэж чадна. Харамсалтай нь эдгээр зорилгуудыг их сургуулийн үйл ажиллагаанд хэрхэн уялдуулах талаар зөвлөмж байхгүй байна. Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээний Австрали, Номхон далайн салбараас шинэ зөвлөмжийг их сургуулиудад зориулж гаргасан

байна. Энэхүү зөвлөмж нь Австрали, Шинэ Зеландын их сургуулиудын туршлагад тулгуурлан оюутан, сурагчдыг тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэх шинэ үеийнхэн болгон бэлтгэх, их сургуулиуд тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулах талаар практик зөвлөмжийг агуулжээ.

ХОЛБОГДОХ ЭХ СУРВАЛЖУУД

“МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”, 2016. Монгол улсын их хурал
Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development. A/70/L.1, Resolution adopted by the General Assembly on 25 September 2015

Ногоон эдийн засгийн барометр. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв. 2018

Монгол улс дахь жендэрийн тулгамдсан асуудлууд. IRIM Судалгааны хүрээлэн. 2014

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2016. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. 2017

Уур амьсгалын өөрчлөлт, хөдөө аж ахуйд түүний үзүүлэх нөлөө, хүнсний аюулгүй байдал. Ж.Мижиддорж. ХАА-н шинжлэх ухаан сэтгүүл. 2015. №14 (01);251-257.

Эдийн засгийн өсөлт, ядуурал, ажилгүйдлийн хамаарлын судалгаа. 2018-ы Статистикийн Үндэсний хороо
2017 global hunger index: The inequalities of hunger.2018. International Food Policy Research Institute.

Эрүүл мэндийн үзүүлэлт. 2016. Эрүүл мэндийн төв

United Nations Academic Impact. <https://academicimpact.un.org/>

Global Innovation Index-2018, WIPO

Fragile State Index-2017. Fund for Peace.

Corruption Perceptions Index- 2017, Transparency International

SUMMARY

The United Nations’ Transforming Our World: The 2030 Agenda for Sustainable Development is one of the most ambitious and important global agreements in recent history. The agenda, with the 17 Sustainable Development Goals (SDGs) at its core, is a guide to tackling the world’s most pressing challenges – including ending poverty and bringing economic prosperity, social inclusion, environmental sustainability and peace and good governance to all countries and all people by 2030. The SDGs also have strong relevance to universities, and the tertiary and academic sectors more broadly. The SDGs cover a wide range of complex social, economic, and environmental challenges and addressing them will require transformations in how societies and economies function and how we interact

with our planet. Education, research, innovation and leadership will be essential in helping society address these challenges. Universities, with their broad remit around the creation and dissemination of knowledge and their unique position within society, have a critical role to play in the achievement of the SDGs. Arguably none of the SDGs will be achieved without this sector. Therefore, we have made a focus of this issue of the policy brief on what universities could bring to implementation of SDGs in Mongolian context. Wide range of best practices, initiatives taken by academia is reflected in this issue in order for Mongolian universities to take an urgent action towards SDG implementation according to the Mongolian concept of Sustainable development -2030.

ШУТИС-ИЙН ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

Тус төв энэ хичээлийн жилээс сар бүр дээд боловсролын тулгамдсан асуудлаар “Дээд боловсролын бодлогын өөрчлөлт” цувралыг хэвлэж гарган, мөн ШУТИС-ийн веб хуудсаар түгээх болно. Эдгээр цуврал нь дээд боловсролын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад зориулагдсан бөгөөд энэ цувралын материалыг ашиглах, өөрсдийн судалгаанд ишлэл татан хэрэглэхийг бүрэн дэмжиж, Creative Commons нээлттэй лицензээр зохиогчийн эрхээ баталгаажуулсан.



Судалгааны баг

Доктор, профессор Д.Бадарч

Доктор, профессор Б.Очирбат

Доктор, дэд профессор Т.Намнан

Судлаач Б.Мөнххүж

Хянан тохиолдуулсан: Б.Очирбат

Хэвлэлд бэлтгэсэн: Ч.Болорчимэг

© ШУТИС Хэвлэлийн газар

